ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 25 өдөр Дугаар 11/02 Даланзадгад сум

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10/16 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 109,573,731.09 (нэг зуун есөн сая таван зуун далан гурван мянга долоон зуун гучин нэгэн төгрөг есөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 5,022,771.60 (таван сая хорин хоёр мянга долоон зуун далан нэгэн төгрөг жаран мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 104,550,959.49 (нэг зуун дөрвөн сая таван зуун тавин мянга есөн зуун тавин есөн төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй барилгуудыг буулган данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газрын дарга (В.Хүүхэндүү)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.

2.2.Хөрөнгийн хөдөлгөөнийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл болон “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-д тусгах.

2.3.Барилгын доорх газрын эзэмших эрхийг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах.

2.4.Тогтоолын биелэлтийг 2026 оны дөрөвдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

Data E; /doc togtool/
4626010309

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн
11/02 дугаар тогтоолын хавсралт

Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газрын акталж, данснаас хасах хөрөнгийн мэдээлэл

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл өртөг /төг/
1	Архив	2004.12.31	ш	1	113,160.91	15,088.00	98,072.91
2	Конторын барилга	1956.12.31	ш	1	25,791,691.75	3,438,892.16	22,352,799.59
3	Соёлын төвийн хуучин барилга	1968.01.22	ш	1	83,668,878.43	1,568,791.44	82,100,086.99
Нийт					109,573,731.09	5,022,771.60	104,550,959.49

٢٠٢٠٠٥ مصنعتنم مر هنمبهم د٧٧٧٩ مم ٩ مصنعهصنس مبهنكبهع هسصنتم مصنم تصصم مر
مصبتر مدم تُمصر هع رصنكوهبهو..

٧٠٠ مُنم مصنصنتم مر ٧نكرتكبهم صع ٧نمبهم مصهوتع مصكبهنع مد مصنبهم مر مسهم مصنمُ)
(تـ٠٠٧٧هوهصو)-٥ مصتتتبهتتواصتتن..

Dokument E: /doc.bgtool.m.by/
4626010150

مؤسسة الحكيم عن
الحكام عن الحكيم عن الحكم عن
الحكيم

الحكيم الحكيم عن الحكم الحكيم، الحكم عن الحكيم، الحكم عن الحكيم عن الحكيم عن الحكي